

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЧУЛУУНБААТАРЫН ЭНХ-ОТГОНЫ
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
Зорилт 1.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.								
1.	Арга хэмжээ 1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын хурлаар хэлэлцүүлэн, зөвлөмж хүргүүлэх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	10	5	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 94 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 зорилт 1 арга хэмжээний биелэлт 100 хувь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилтын 10 арга хэмжээний биелэлт 97 хувь, нийслэлийн Хөгжлийн 2024		01-12	100%

					оны төлөвлөгөөний 1 зорилтын 19 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 95 хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх 2 зорилтын 10 арга хэмжээний хэрэгжилт 89 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 98,8 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 96.6 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 94.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Хяналт шинжилгээ үнэлгээгээр холбогдох хэлтэс, албан хаагчдад илтгэх хуудсаар зөвлөмж гаргаж хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 1.2 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын байгууллагын чиг үүрэгт хамаарах заалтын тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд хийнэ.	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	8	5	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн 2024 оны жилийн эцсийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 98 хувь, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 97 хувь, нийслэлийн Засаг даргын 2024 оны албан даалгаврын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй тус тус үнэлэгдсэн.	01-12	100%
3.	Арга хэмжээ 1.3 Төсвийн Ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах 2024 оны "Хариуцлагын гэрээ"-ний тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	1	1	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2024 оны "Хариуцлагын гэрээ"-ний 2024 оны жилийн эцсийн тайланд хийсэн	01-12	100%

					хяналт шинжилгээ, үнэлгээгээр 97 хувьтай үнэлэгдсэн.		
4.	Арга хэмжээ 1.4 “Хариуцлагын гэрээ”-ээр төсвийн шууд захирагчийн хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд хийнэ.	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	2	1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан 2024 оны “Хариуцлагын гэрээ”-ний 21 заалтын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалаар дүгнэхэд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан 2024 оны “Хариуцлагын гэрээ”-ний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 93 хувьтай буюу “Бүрэн хэрэгжсэн” хэмээн үнэлсэн.	06-12	100%
5.	Арга хэмжээ 1.5 Байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, тайланг нэгтгэж тогтоосон хугацаанд тайлагнана.	Батлуулсан төлөвлөгөөний тоо	1	1	Байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. Төлөвлөгөөний дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээг улирлаар, хагас болон жилийн эцсээр үнэлгээ хийсэн. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ нь чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэхэд шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор дотоод хяналт шинжилгээг 2024 оны 8 дугаар сард хийсэн. Энэхүү дотоод хяналт шалгалтаар чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын шаардлага хангасан гэж үнэлсэн. Тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайланг хүргүүлсэн.	06-12	100%

6.	Арга хэмжээ 1.6 Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж хүргүүлэх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	2	1	2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын нийт 43 арга хэмжээнд тусгагдсан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан аргачлалаар дүгнэхэд нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 97 хувьтай буюу "Бүрэн хэрэгжсэн" хэмээн үнэлэгдэв. Үнэлгээг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, илтгэх хуудсаар зөвлөмж гарган баталгаажуулсан.	01-12	100%
7.	Арга хэмжээ 1.7 Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	2	1	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн дүн 94,6 хувьтай үнэлэгдсэн.	01-12	100%
8.	Арга хэмжээ 1.8 Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	2	1	Нийслэл дэх Төрийн аудитын газраас байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай үнэлэгдсэн. Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын	01-12	100%

					тайлангаас нутгийн захиргааны байгууллагуудад гаргасан зөвлөмжийн хүрээнд өөрийн байгууллагад хамаарах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан хэрэгжилтийг 2025 оны хагас, бүтэн жилээр тайлагнан, хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.		
9.	Арга хэмжээ 1.9 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тогтоосон хугацаанд тайлагнана.	Цахимаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	-	12	Нийслэлийн удирдах ажилтнуудын 17 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 51 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнаж, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тайланд үнэлгээ хийж, зөвлөмж гарган ажилласан.	01-12	100%
7.	Арга хэмжээ 1.10 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг гадаад, дотоодын иргэдээс авч, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Судалгааны тоо	2	3	Байгууллагын үндсэн чиг хүрээнд тогтмол зохион байгуулдаг эвент арга хэмжээнүүдийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, оролцогчдын сэтгэл ханамжийг үнэлэх, эдийн засгийн үр ашигт таамаглал дэвшүүлэх, эвентийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нөлөөлж буй сэдэлжүүлэлт, нийгэм-эдийн засгийн үр ашигт байдлыг үнэлэх зорилгоор Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн Олон улсын аялал жуулчлалын сургалт, судалгааны институттай хамтран “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Талын салхи” олон улсын мото наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль” зэрэг 7 эвент арга хэмжээний судалгааны ажлыг зохион байгуулж, гадаадын 502, дотоодын 1494, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхлэгч 288, худалдаа үйлчилгээ эрхлэгч 407 нийт 2691 хүнээс судалгаа авч, арга хэмжээнүүдийг	02-12	100%

					гадаад, дотоодын нийт 173,000 гаруй хүн үзэж сонирхон. Улаанбаатар хотын эдийн засагт 16.036.000.000 тэрбум төгрөгийг эргэлтэд оруулсан байна.		
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.	Арга хэмжээ 2.1 Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, заавар, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн хувь	90%	95%	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу зохион хөтөлж, албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой ирсэн нийт 13 албан бичиг, 4 өргөдлийг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн. Хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй.	01-08	100%
2.	Арга хэмжээ 2.2 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгнө.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны 2 хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгсөн.	01-03	100%
3.	Арга хэмжээ 2.3 Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар өгсөн үүрэг даалгавар бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	“Талын салхи-2024” олон улсын мото фестивалийн оролцогчдоос сэтгэл ханамжийн болон эдийн засгийн үр өгөөжийг тооцох судалгаа авах үүрэг даалгаварыг биелүүлж судалгааны асуулгыг боловсруулж, асуулгуудыг Хятад, Солонгос хэл рүү орчуулах, судалгаа авах, судалгааг нэгтгэх ажлыг зохион байгуулан ажилласан. Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.	01-12	100%

Зорилт 3. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1	Хамрагдсан сургалтын тоо	6	4	- Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор Төрийн	01-12	100%

	Хариуцсан чиглэлийн хүрээнд сургалт, семинарт, зөвлөгөөнд хамрагдаж тухай бүр мэдлэг чадвараа дээшлүүлнэ.				албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт зохион байгуулдаг "4-7-10" сургалт, - "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн төсөл"-ийг танилцуулах "4-7-10" сургалт, - "Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн хэрэгжилт"-ийг хангуулах "4-7-10" сургалт, байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах хоёр удаагийн сургалт, Ёс зүйн дэд хорооноос ёс зүй, харилцаа хандлагыг сургалтыг санаачлан зохион байгуулж, нийт албан хаагчийг хамруулсан. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал" хэлэлцүүлэгт - Удирдлагын академиас зохион байгуулсан "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" сургалт - Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан "Тогтвортой, жендэрийн мэдрэмжтэй аялал жуулчлал" хэлэлцүүлэг - Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт - "ISO 9001:2015" чанарын менежментийн тогтолцооны стандартын дотоод аудит бэлтгэх сургалт нийт 8 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнд хамрагдсан. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сэдэвт танхимын сургалтад хамрагдсан. - Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сэдэвт танхимын сургалтад хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 2	Цаг	-	24	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны 24 цагийн сургалтад хамрагдсан.	03	100%

	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сургалтад хамрагдана.						
3.	Арга хэмжээ 3 Солонгос хэлний сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлнэ.	Цаг	-	144	Солонгос хэлний 144 цагийн анхан шатны сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлсэн.	01-10	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үндэсний Их баяр наадмыг үзэх жуулчдад зориулсан билетийг хуваарилах ажлын хэсэгт орж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Үндэсний их баяр наадмыг үзэх жуулчдад зориулсан тасалбар хуваарилах ажлыг зохион байгуулсан. Мөн жуулчдад мэдээлэл зөвлөгөө өгөх, жуулчдын секторт хяналт тавих ажлыг багийн гишүүдтэй хамтран хийсэн. Жуулчдад зориулсан 2204 тасалбар, 100 автомашины зөвшөөрлийг 216 аж ахуй нэгжид хуваарилан тараасан.	07/01-07/11	100%
2.	Олон нийтийн арга хэмжээнд оролцох	Арга хэмжээний тоо	1	2	Цас цэвэрлэгээнд 2 удаа, "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээнд 2 удаа, мод тарих өдрийн арга хэмжээнүүдэд оролцсон.	01/02-06/20	100%
3.	Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд шинээр батлагдсантай холбогдуулан нийт ажилтнуудын дунд санал асуулга зохион байгуулж хамгийн өндөр санал авсан 3 мэргэжилтнийг сонгож нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/45 тушаалаар ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Ёсзүйн дэд хорооны гишүүнээр сонгогдон тус хороонд ажиллаж байна.	01-12	100%

4.	"UB Food Festival-2024" арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэл	100%	100%	Монголын үндэсний хоол болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах "UB Food Festival-2024" арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, хамтарч ажилласан.	03/02-08/27	100%
5.	Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр болон олон улсын туршлагыг судлах, экспертийн төрөлжсөн сургалтуудыг хамтран зохион байгуулах	Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	647	100	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны үйлчилгээний байгууллагын удирдлага, ажилчдад зориулсан сургалтыг Аялал Жуулчлалын Мэргэжлийн холбоо, "Эксперт Хоспиталити" ХХК-тай хамтран 2024 оны 05 дугаар сарын 06-09-ны өдүүдэд зохион байгуулсан. Тус сургалт нь зочлох үйлчилгээний байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн Зочид буудлын үйлчилгээ, Зоогийн газрын үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй, захирал, менежерүүд болон үйлчилгээний ажилтнууд гэсэн хоёр түвшинд зохион байгуулагдсан. Сургалтад нийт 26 байгууллагын 140 хүн хамрагдсан.	05/03-12/10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч. Энх-Отгон

Ч.ЭНХ-ОТГОН

2024 оны *12* дугаар сарын *05*..